



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/069-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsogjargalb@audit.gov.mn</p>
---	--

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.13 № 32

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА
В.БААСАНЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд түрээсийн төлбөр болох 38,841.2 мянган төгрөгийн орлогыг тогтоосон хугацаанд төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй авлага үүсгэсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийг зөрчсөн бөгөөд аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант 911,759.7 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 815,822.1 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтуудыг хангахад чиглэсэн 4 зорилт, 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас 91.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	4,875,666.04	38,841,200.00
33500	Бусад авлага	4,875,666.04	38,841,200.00
33510	Байгууллагаас авах авлага	185.96	38,841,200.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,875,480.08	-
35	БАРАА МАТЕРИАЛ	385,830,891.00	376,727,669.83
35100	Түүхий эд материал	3,879,652.00	3,432,289.00
35110	Тусгай зориулалттай материал	3,879,652.00	3,432,289.00
35400	Хангамжийн материал	338,391,239.00	335,425,380.83
35410	Бичиг хэргийн материал	1,343,741.00	1,395,878.00
35440	Түлш, шатах тослох материал	400,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	336,647,498.00	334,029,502.83
35600	Мал амьтад	43,560,000.00	37,870,000.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	390,706,557.04	415,568,869.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,418,939,248.35	1,168,705,730.94
39200	Биет хөрөнгө	1,384,566,748.19	1,135,078,230.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	406,708,210.00	406,708,210.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(54,835,769.76)	(64,621,803.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,704,932,280.49	1,704,932,280.49
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(784,411,301.24)	(1,013,123,671.52)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	193,294,383.45	213,972,973.45
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(94,926,146.78)	(121,192,993.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,143,513.15	43,670,013.15
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(26,078,706.09)	(35,907,249.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,096,088.00	2,096,088.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(1,355,803.03)	(1,455,616.75)
39300	Биет бус хөрөнгө	34,372,500.16	33,627,500.00
39301	Програм хангамж	4,700,000.00	4,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(3,517,499.84)	(4,262,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	33,190,000.00	33,190,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	1,418,939,248.35	1,168,705,730.94
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,809,645,805.39	1,584,274,600.77
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	44,212,255.04	53,235,700.00
41300	Өглөг	44,212,255.04	53,235,700.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	481,250.00	-
41312	НДШ-ийн өглөг	481,250.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,020,139.00	3,149,250.00
413201	Бичиг хэргийн өглөг	-	1,964,750.00

Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

413203	Түлш халаалтын өглөг	2,020,139.00	-
413213	Бусад зардлын өглөг	-	1,184,500.00
41360	Бусад өглөг	41,710,866.04	50,086,450.00
41361	Байгууллагад төлөх өглөг	41,710,866.04	39,707,250.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	10,379,200.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	44,212,255.04	53,235,700.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,765,433,550.35	1,531,038,900.77
51101	-Төрийн	1,580,093,081.39	1,580,093,081.39
51200	Хуримтлагдсан үр дүн	66,727,856.89	(167,666,792.69)
51210	Өмнөх үеийн үр дүн	(869,348,223.50)	66,727,856.89
51220	Тайлант үеийн үр дүн	936,076,080.39	(234,394,649.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	118,612,612.07	118,612,612.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,765,433,550.35	1,531,038,900.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,809,645,805.39	1,584,274,600.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,217,181,392.00	893,348,589.96
1310	Улсын төсвөөс	1,094,257,372.00	819,300,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,094,257,372.00	819,300,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	122,924,020.00	74,047,989.96
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,386,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	11,683,800.00	1,388,620.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	67,691,220.00	72,430,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	42,163,000.00	229,369.96
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	1,380,377,213.06	199,546,290.00
1200	Нийтлэг татварын бус орлого	1,380,377,213.06	199,546,290.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	120,000.00	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	120,000.00	100,000.00
120005	Түрээсийн орлого	2,006,000.00	38,841,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,141,818,543.46	20,205,090.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	236,432,669.60	140,400,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,597,558,605.06	1,092,894,879.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,598,308,876.27	1,326,931,639.14
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,485,007,081.02	1,321,357,777.88
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	710,431,538.52	703,485,749.00
210101	Үндсэн цалин	419,084,259.97	380,410,791.31
210102	Нэмэгдэл	222,654,578.55	230,054,755.11
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	27,058,000.00	41,910,000.00

Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210104	Урамшуулал	41,634,700.00	51,110,202.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,383,393.00	89,059,663.22
210201	Тэтгэврийн даатгал	60,744,740.24	60,560,570.28
210202	Тэтгэмжийн даатгал	7,095,718.71	7,124,772.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,800,596.51	3,562,386.51
210204	Ажилгүйдлийн даатгал	3,550,901.93	3,562,387.51
210205	Эрүүл мэндийн даатгал	14,191,435.61	14,249,545.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,560,472.23	48,917,911.48
210301	Гэрэл, цахилгаан	1,520,285.00	1,771,125.00
210302	Түлш, халаалт	32,161,113.00	46,414,168.50
210303	Цэвэр, бохир ус	879,074.23	732,617.98
2104	Хангамж, бараа материалын зардал	26,401,856.00	26,425,600.17
210401	Бичиг хэрэг	3,532,700.00	6,236,550.00
210402	Тээвэр, шатахуун	12,415,893.00	7,089,622.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,023,300.00	2,552,120.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	225,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	673,500.00	356,750.00
210408	Бараа материал актласны зардал	7,456,463.00	9,965,558.17
2105	Нормативт зардал	68,100.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	68,100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,275,300.00	7,628,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,075,300.00	1,473,000.00
210604	Урсгал засвар	10,200,000.00	6,155,400.00
2107	Томилолт, зочны зардал	24,070,800.00	26,146,300.00
210702	Дотоод албан томилолт	24,070,800.00	26,146,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,325,814.00	2,607,674.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,670,900.00	1,103,834.00
210803	Даатгалын үйлчилгээ	575,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	219,044.00	67,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,848,000.00	1,436,840.00
210807	Газрын төлбөр	12,870.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	462,489,807.27	417,086,480.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	187,309,248.00	141,277,872.60
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	370,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	275,180,559.27	275,438,607.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,301,795.25	5,573,861.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,749,172.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,400,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	87,786,172.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,563,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,552,623.25	5,573,861.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,465,623.25	3,478,491.30
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,087,000.00	2,095,369.96
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,598,308,876.27	1,326,931,639.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	999,249,728.79	(234,036,759.18)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	63,173,648.40	357,890.40
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,720,730.80	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал зардал - бараа материал	56,452,917.60	357,890.40

5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	63,173,648.40	357,890.40
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	936,076,080.39	(234,394,649.58)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,234,164,236.36	898,224,256.00
1310	Улсын төсвөөс	1,094,257,372.00	819,300,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,094,257,372.00	819,300,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	139,906,864.36	78,923,656.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,386,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	11,683,800.00	1,388,620.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,691,220.00	72,430,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	59,145,844.36	5,105,036.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,234,164,236.36	898,224,256.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,234,164,236.36	893,224,256.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,109,618,896.75	887,650,394.74
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	710,431,538.52	703,485,749.00
210101	Үндсэн цалин	419,084,259.97	380,410,791.31
210102	Нэмэгдэл	222,654,578.55	230,054,755.11
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	27,058,000.00	41,910,000.00
210104	Урамшуулал	41,634,700.00	51,110,202.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,902,143.00	89,540,913.22
210201	Тэтгэврийн даатгал	60,263,490.24	61,041,820.28
210202	Тэтгэмжийн даатгал	7,095,718.71	7,124,772.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,800,596.51	3,562,386.51
210204	Ажилгүйдлийн даатгал	3,550,901.93	3,562,387.51
210205	Эрүүл мэндийн даатгал	14,191,435.61	14,249,545.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,540,333.23	50,938,050.48
210301	Гэрэл, цахилгаан	1,520,285.00	1,771,125.00
210302	Түлш, халаалт	30,140,974.00	48,434,307.50
210303	Цэвэр, бохир ус	879,074.23	732,617.98
2104	Хангамж, бараа материалын зардал	17,368,920.00	13,202,942.00
210401	Бичиг хэрэг	2,591,200.00	4,461,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,780,920.00	6,689,622.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,023,300.00	1,686,070.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	225,000.00

Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	673,500.00	140,650.00
2105	Нормативт зардал	68,100.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	68,100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,225,300.00	7,478,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,025,300.00	1,473,000.00
210604	Урсгал засвар	10,200,000.00	6,005,400.00
2107	Томилолт, зочны зардал	24,070,800.00	15,767,100.00
210702	Дотоод албан томилолт	24,070,800.00	15,767,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,782,814.00	3,627,574.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	188,127,900.00	1,103,834.00
210803	Даатгалын үйлчилгээ	575,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	219,044.00	67,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,848,000.00	2,456,740.00
210807	Газрын төлбөр	12,870.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,228,948.00	3,609,666.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,228,948.00	3,239,666.04
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	370,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,545,339.61	5,573,861.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,749,172.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,400,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	87,786,172.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,563,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,796,167.61	5,573,861.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,465,623.25	3,478,491.30
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	14,330,544.36	2,095,369.96
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	1,234,164,236.36	893,224,256.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	5,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,000,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	5,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	5,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	(5,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,580,093,081.39	118,612,612.07	66,727,856.89	1,765,433,550.35
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,580,093,081.39	118,612,612.07	66,727,856.89	1,765,433,550.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,580,093,081.39	118,612,612.07	66,727,856.89	1,765,433,550.35
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(234,394,649.58)	(234,394,649.58)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,580,093,081.39	118,612,612.07	(167,666,792.69)	1,531,038,900.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	911,759,700.0	819,300,600.0	92,459,100.0	89.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	911,759,700.0	819,300,600.0	92,459,100.0	89.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,662,500.0	815,822,108.7	50,840,391.3	94.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	640,816,500.0	640,816,500.0	-	100.0
210101	Үндсэн цалин	405,432,900.0	380,410,791.3	25,022,108.7	93.8
210102	Нэмэгдэл	155,590,200.0	167,385,506.1	(11,795,306.1)	107.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,650,500.0	41,910,000.0	(10,259,500.0)	132.4
210104	Урамшуулал	48,142,900.0	51,110,202.6	(2,967,302.6)	106.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,783,800.0	80,588,162.2	195,637.8	99.8
210201	Тэтгэврийн даатгал	54,946,800.0	54,953,950.3	(7,150.3)	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,459,200.0	6,408,552.9	50,647.1	99.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,229,600.0	3,204,276.5	25,323.5	99.2
210204	Ажилгүйдлийн даатгал	3,229,600.0	3,204,276.5	25,323.5	99.2
210205	Эрүүл мэндийн даатгал	12,918,600.0	12,817,106.0	101,494.0	99.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,937,600.0	50,938,050.5	1,999,549.5	96.2
210301	Гэрэл, цахилгаан	3,732,400.0	1,771,125.0	1,961,275.0	47.5
210302	Түлш, халаалт	47,886,200.0	48,434,307.5	(548,107.5)	101.1
210303	Цэвэр, бохир ус	1,319,000.0	732,618.0	586,382.0	55.5

2104	Хангамж, бараа материалын зардал	14,777,100.0	12,546,322.0	2,230,778.0	84.9
210401	Бичиг хэрэг	4,647,100.0	4,461,600.0	185,500.0	96.0
210402	Тээвэр, шатахуун	7,900,000.0	6,033,002.0	1,866,998.0	76.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,780,800.0	1,686,070.0	94,730.0	94.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270,000.0	225,000.0	45,000.0	83.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	179,200.0	140,650.0	38,550.0	78.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,903,000.0	12,478,400.0	3,424,600.0	78.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,723,000.0	6,473,000.0	250,000.0	96.3
210604	Урсгал засвар	9,180,000.0	6,005,400.0	3,174,600.0	65.4
2107	Томилолт, зочны зардал	16,499,900.0	14,457,100.0	2,042,800.0	87.6
210702	Дотоод албан томилолт	16,499,900.0	14,457,100.0	2,042,800.0	87.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,938,500.0	3,627,574.0	35,310,926.0	9.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,138,400.0	1,103,834.0	25,034,566.0	4.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	143,300.0	-	143,300.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	537,500.0	-	537,500.0	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,800.0	67,000.0	161,800.0	29.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,700.0	-	88,700.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,770,400.0	2,456,740.0	9,313,660.0	20.9
210807	Газрын төлбөр	31,400.0	-	31,400.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,006,100.0	370,000.0	5,636,100.0	6.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,636,100.0	-	5,636,100.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	370,000.0	370,000.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,097,200.0	3,478,491.3	41,618,708.7	7.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,097,200.0	-	45,097,200.0	0.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,862,000.0	-	2,862,000.0	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,735,200.0	-	40,735,200.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.0	-	1,500,000.0	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,923,656.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,923,656.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,828,286.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,669,249.0
210102	Нэмэгдэл	62,669,249.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,952,751.0
210201	Тэтгэврийн даатгал	6,087,870.0
210202	Тэтгэмжийн даатгал	716,220.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	358,110.0
210204	Ажилгүйдлийн даатгал	358,111.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,432,440.0
2104	Хангамж, бараа материалын зардал	656,620.0
210402	Тээвэр, шатахуун	656,620.0
2107	Томилолт, зочны зардал	1,310,000.0
210702	Дотоод албан томилолт	1,310,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,239,666.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,239,666.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,095,370.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,095,370.0
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	2,095,370.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	76,828,286.0
13	ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,828,286.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,828,286.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	1,388,620.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	72,430,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,009,666.0
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,095,370.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,110.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Тайлант оны санхүүгийн тайланд мал амьтад дансны үлдэгдлийг няравын тайлангаас 1,110.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасныг аудитын явцад залрууллаа. Энэ нь НББ-ын тухай хуулийн 5.1.4, 13.1, 14.4.1, 15.1, 15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Залруулаагүй нийт 40,336.0 мянган төгрөгийн зөрчилд² зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 2, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 40,336.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 6,134.4 мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. Тус байгууллага нь “Тунгалаг тамир цогцолбор” ОНӨААТҮГ-тай байгуулсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түр ашиглуулах гэрээ”-ны дагуу 38,841.2 мянган төгрөгийн түрээсийн төлбөр авахаар харилцан тохиролцсон боловч тайлант онд орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, гэрээнд өмч эзэмшигч болон ашиглагч талуудын зүгээс нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах талаар тусгаагүй, өмч эзэмшигчийн зүгээс гэрээний үүргийг биелүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байхад 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэрээг дүгнэж, төлбөрийг 2026 онд төлүүлэхээр хугацааг хойшлуулсан актыг үйлдэж 38,841,200 төгрөгийн авлагын үлдэгдэл үүсгэж тайлагнасан байна. Өөрөөр хэлбэл төсөвт орох орлогыг бусдад ашиглуулж, өөрийн байгууллагын төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэхгүй хойшлуулж үр дүнг бууруулсан байж болзошгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалт, 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түр ашиглуулах 01 дугаар гэрээний холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний хэрэгжилтийг хангуулж түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

3.1.2 Тайлант онд үндсэн санхүүжилтээс нийт 6,459.6 мянган төгрөгийг шатахуунд зарцуулсан байна. Үүнээс анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу шаардах хуудсаар төсөв захирагч зарцуулах зөвшөөрөл олгоогүй байхад 1,494.8 мянган төгрөгийн шатахууныг хяналтгүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар гүйлгээ хийж бүртгэж тайлагнасан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлээ.

3.1.3 Өмнөх оны аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон зөрчил илэрсэнд таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн. Гэтэл тайлант онд Шилэн дансанд байршуулбал зохих 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж өмнөх зөрчлийг давтан гаргасан байна.

Иймд өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байх тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасан "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ... албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэсэн заалтын дагуу нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 38,841.2 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.	1	38,841.2			1	38,841.2
Анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,494.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.	1	1,494.8			1	1,494.8
Нийт дүн	2	40,336.0			2	40,336.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант хугацаанд шилэн дансанд 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	0	0	0	1	0
Дүн	1	0	0	0	1	0